



**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

**Дүүргийн нутаг дэвсгэрт мөрдөх хог
хаягдлын үйлчилгээний хураамжийн
хэмжээг шинэчлэн тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.16, 25 дугаар зүйлийн 25.1.4, 25 дугаар зүйлийн 25.1.14, 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.2.2 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.6 дахь хэсэг, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.23 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.1, 67.2 дугаар хэсэг, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192, А/243 дугаар тушаал, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2022 оны А/82 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр албан даалгаварыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус 19 дүгээр хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт хог хаягдлын үйлчилгээний хураамжийг шинэчилж, нэг өрхөд тооцох зардлыг нэгдүгээр, үйлдвэр аж ахуйн газарт тооцох зардлыг хоёрдугаар, төрийн болон төсөвт байгууллагад тооцох зардлыг гуравдугаар, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнд тооцох зардлыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг дүүргийн төсөвт төвлөрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахыг дүүргийн Засаг дарга (А.Сүхболд)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны А/01 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Дүүргийн өрх, үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгч, иргэний хог хаягдлын хураамжийн төлбөрийг Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтэлсний дараа, төрийн болон төсөвт байгууллагуудын хог хаягдлын хураамжийн төлбөрийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн
115 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



НЭГ ӨРХӨД ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХУРААМЖИЙГ ТООЦОХ ЗАРДАЛ

	Үзүүлэлт	Нэгж	ГХ	ОС	Нийт
1	Хүн амын тоо	тоо	1534	2882	4414
2	Нэг иргэнээс өдөрт үүсэх хог хаягдлын хэмжээ	гр/иргэн/өдр	1146	422	784
3	Нэг жилд сууринд үүсэх хог хаягдлын хэмжээ	тн	641.65686	443.91446	1085.57132
4	Нэг тонн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булшлах нийт зардал	тн/төг	50,073.9	50,073.9	50,073.9
5	Нийт зардал	Жил/мян.төг	32,130.23	22,228.51	54,358.74
6	Хог хаягдлын хураамж төлөх иргэдийн тоо	Хүн/тоо	928	1848	2776
7	Нэг иргэнд ногдох хог хаягдлын хураамж	Сар/төг	2885.25806	1,002.37	1,631.81
8	Нэг өрх ногдох хог хаягдлын хураамж	Сар/төг	4800 төгрөг		

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн
115 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН ГАЗАРТ ХОГ ХАЯГДЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙГ ТООЦОХ ЗАРДАЛ

№	Үзүүлэлт	Нэгж	Тоо	Тайлбар
1	Аж ахуй нэгжийн өдөрт үүсгэх хог хаягдлын хэмжээ	өдөр/тн	0.1	Ажлын зураг авалтаар
2	Аж ахуй нэгжийн жилд ажиллах өдрийн тоо	тоо	180	Тухайн аж ахуйн нэгжийн нэг жилд ажиллах ажлын өдөр
3	Аж ахуй нэгжийн жилд үүсгэх хог хаягдлын хэмжээ	жил/тн	18	$C=A*B$
4	Нэг тонн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардал	төг/тн	50,074	Холбогдох аргачлалын дагуу
5	Нэг тонн хог хаягдлыг төвлөрсөн цэгт дарж булшлах зардлан хэмжээ	төг/тн	6,326	Холбогдох аргачлалын дагуу
6	Нэг жилд үүсэх хог хаягдлыг цуглуулах зөөж тээвэрлэх, булшлах нийт зардал	төг/жил	1,015,201	$F=(D+E)*C$
7	Нэг сард аж ахуй нэгжид ногдох хог хаягдлын үйлчилгээний хураамж	төг/сар	84,600	$G=F/12$

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн
115 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

ТӨРИЙН БОЛОН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГАД ХОГ ХАЯГДЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙГ ТООЦОХ ЗАРДАЛ

№	Үзүүлэлт	Нэгж	Тоо	Тайлбар
1	Аж ахуй нэгжийн өдөрт үүсгэх хог хаягдлын хэмжээ	өдөр/тн	0.05	Ажлын зураг авалтаар
2	Аж ахуй нэгжийн жилд ажиллах өдрийн тоо	тоо	180	Тухайн аж ахуйн нэгжийн нэг жилд ажиллах ажлын өдөр
3	Аж ахуй нэгжийн жилд үүсгэх хог хаягдлын хэмжээ	жил/тн	9	$C=A*B$
4	Нэг тонн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардал	төг/тн	50,074	Холбогдох аргачлалын дагуу
5	Нэг тонн хог хаягдлыг төвлөрсөн цэгт дарж булшлах зардлан хэмжээ	төг/тн	6,326	Холбогдох аргачлалын дагуу
6	Нэг жилд үүсэх хог хаягдлыг цуглуулах зөөж тээвэрлэх, булшлах нийт зардал	төг/жил	507,600	$F=(D+E)*C$
7	Нэг сард аж ахуй нэгжид ногдох хог хаягдлын үйлчилгээний хураамж	төг/сар	42,300.0	$G=F/12$

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн
115 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт

ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ, ИРГЭНИЙ
ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙГ ТООЦОХ ЗАРДАЛ

№	Үзүүлэлт	Нэгж	Тоо	Тайлбар
1	Аж ахуй нэгжийн өдөрт үүсгэх хог хаягдлын хэмжээ	өдөр/тн	0.02	Ажлын зураг авалтаар
2	Аж ахуй нэгжийн жилд ажиллах өдрийн тоо	тоо	180	Тухайн аж ахуйн нэгжийн нэг жилд ажиллах ажлын өдөр
3	Аж ахуй нэгжийн жилд үүсгэх хог хаягдлын хэмжээ	жил/тн	3.6	$C=A*B$
4	Нэг тонн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардал	төг/тн	50,073.9	Холбогдох аргачлалын дагуу
5	Нэг тонн хог хаягдлыг төвлөрсөн цэгт дарж булшлах зардлан хэмжээ	төг/тн	6,326.2	Холбогдох аргачлалын дагуу
6	Нэг жилд үүсэх хог хаягдлыг цуглуулах зөөж тээвэрлэх, булшлах нийт зардал	төг/жил	203,040.1	$F=(D+E)*C$
7	Нэг сард аж ахуй нэгжид ногдох хог хаягдлын үйлчилгээний хураамж	төг/сар	16,920.0	$G=F/12$